663	Өдрийн мэс засал	3827841	Шууны өнгөц гэмтэл, шарх	S51	Өдрийн мэс засал	86.22, 86.28	1.233	477,000	53,000	530,000
664	Өдрийн мэс засал	382812	Бугуй ба сарвууны түвшинд, булчин ба шөрмөс гэмтэл	S66	Өдрийн мэс засал	82.4, 82.5, 82.7, 82.8	1.349	522,000	58,000	580,000
665	Өдрийн мэс засал	3807141	Бусад дотор эрхтэн халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх	T28	Өдрийн мэс засал	42.92	2.512	972,000	108,000	1,080,000
666	Өдрийн мэс засал	381423	Ходоодны өмөн	C16	Өдрийн мэс засал	43.4	2.442	1,050,000		1,050,000
667	Өдрийн мэс засал	3814241	Ходоодны өмөн	C16	Өдрийн мэс засал	42.92	2.512	1,080,000		1,080,000
668	Өдрийн мэс засал	3814441	Бүдүүн, шулуун гадас, хошногоны өмөн	C17, C18, C19, C20, C21	Өдрийн мэс засал	45.4, 48.3	1.860	800,000		800,000
669	Өдрийн мэс засал	3820041	Улаан хоолойн өмөн	C15	Өдрийн мэс засал	42.3	2.442	1,050,000		1,050,000
670	Өдрийн мэс засал	3820042	Улаан хоолойн өмөн	C15	Өдрийн мэс засал	42.92	2.512	1,080,000		1,080,000
671	Өдрийн мэс засал	382062	Элэг ба алгэн дэх цэсний суугийн өмөн	C22, C23	Өдрийн мэс засал	54.91	1.023	440,000		440,000
672	Өдрийн мэс засал	382822	Бөөр, шээсний замын өмөн	C64, C65, C66, C67, C68	Өдрийн мэс засал	55.02, 56.33	1.163	500,000		500,000
673	Өдрийн мэс засал	380052	Эм бэлэг эрхтний өмөн	C51, C54, C55, C56, C57, C58	Өдрийн мэс засал	54.91	1.512	650,000		650,000
674	Өдрийн мэс засал	380122	Үр хөндөлт, умай гаднах жирэмсэн ба цулцан хурьтай холбоотой хүчдрэл	O00, O01, O02, O08	Өдрийн мэс засал	69	0.465	180,000	20,000	200,000
675	Өдрийн мэс засал	382853	Эмнэлгийн үр хөндөлт	O04	Өдрийн мэс засал	69.01, 69.02, 69.5, 73.4	0.186	72,000	8,000	80,000
676	Өдрийн мэс засал	381112	Мадралийн болон бусад эрхтний сүрьеэ	A18	Өдрийн мэс засал	40.2	0.930	400,000		400,000
677	Сэргээн засах	350011	Арсны эмгэгийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.8, Z50.9	Далгасан сэргээн засах		1.000	700,000		700,000

678	Сэргээн засах	350012	Ахмадын сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.3, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	2.320	1,624,000		
679	Сэргээн засах	350013	Гэмтэл, согооны сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.2, Z50.3, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	2.199	1,539,000		
680	Сэргээн засах	350014	Дотрын эмгэгийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.1, Z50.3, Z50.4, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	2.334	1,634,000		
681	Сэргээн засах	350015	Тархи, мэдрэлийн гэрэлтэй сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.1, Z50.4, Z50.5, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	2.530	1,771,000		
682	Сэргээн засах	350016	Үе мөч, тулгуур эрхтний сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	1.886	1,320,000		1,320,000
683	Сэргээн засах	350017	Хавдрын дараах сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.1, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	1.053	737,000		737,000
684	Сэргээн засах	350018	Хүүхдийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.1, Z50.4, Z50.6, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	1.607	1,125,000		1,125,000
685	Сэргээн засах	350019	Эх барих эмгэгтэйчүүдийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.1, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	1.203	842,000		842,000
686	Сэргээн засах	350020	Сэтгэцийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Z50.2, Z50.3, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	1.189	832,000		832,000
687	Сэргээн засах	350022	Сэргээн засахын амбулаторийн тусламж, үйлчилгээ	Z50.0, Z50.2, Z50.3, Z50.7, Z50.8, Z50.9, Z50.5	Дагнасан сэргээн засах	0.029	20,000		20,000
688	Сэргээн засах	350023	Сэргээн засахын өдрийн эмчилгээ	Z50.0, Z50.2, Z50.3, Z50.7, Z50.8, Z50.9	Дагнасан сэргээн засах	0.214	150,000		150,000
689	Хөнгөөчлөх	360011	Хорт хавдрын болон бусад өвчний үеийн хөнгөөчлөх эмчилгээ, үйлчилгээ	Z51.5	Эмийн эмчилгээ	1.000	880,000		880,000
690	Уламжлалт	370011	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMA	Уламжлалт анагаах ухаан	1.176	449,650	79,350	529,000
691	Уламжлалт	370012	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMB	Уламжлалт анагаах ухаан	0.916	350,200	61,800	412,000
692	Уламжлалт	370013	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMC	Уламжлалт анагаах ухаан	0.896	342,550	60,450	403,000
693	Уламжлалт	370014	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMD	Уламжлалт анагаах ухаан	0.862	329,800	58,200	388,000
694	Уламжлалт	370015	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TME00-TME06	Уламжлалт анагаах ухаан	1.171	447,950	79,050	527,000
695	Уламжлалт	370016	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMG01	Уламжлалт анагаах ухаан	0.836	319,600	56,400	376,000

Handwritten notes and stamps in the right margin of the table, including a red stamp with Mongolian text and numerical values.

696	Уламжлалт	370017	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMG02-TMG07	Уламжлалт анагаах ухаан		0.889	340,000	60,000	400,000
697	Уламжлалт	370018	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMG08-TMG09	Уламжлалт анагаах ухаан		0.880	336,600	59,400	986,000
698	Уламжлалт	370019	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMJ00	Уламжлалт анагаах ухаан		1.056	403,750	71,250	475,000
699	Уламжлалт	370020	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMK00-TMK05	Уламжлалт анагаах ухаан		1.144	437,750	77,250	1117148648 515,000
700	Уламжлалт	370021	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMM02-TMM17	Уламжлалт анагаах ухаан		1.222	467,500	82,500	550,000
701	Уламжлалт	370023	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMR00-TMR01	Уламжлалт анагаах ухаан		1.353	517,650	91,350	609,000
702	Уламжлалт	370024	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	TMS03-TMS04	Уламжлалт анагаах ухаан		1.216	464,950	82,050	547,000
703	Уламжлалт	370027	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх ангилагдаагүй бусад тусламж, үйлчилгээ		Уламжлалт анагаах ухаан		0.511	195,500	34,500	230,000
704	Уламжлалт	370025	Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээ	TMA-TMW03	Уламжлалт анагаах ухаан		0.044	20,000		20,000
705	Уламжлалт	370026	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээ	TMA-TMW03	Уламжлалт анагаах ухаан		0.333	127,500	22,500	150,000



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01
дүгээр тогтоолын хоёрдугаар хэсэрт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН
ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН АРГА**

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын сангаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг худалдан авахад энэхүү төлбөрийн аргыг баримтална¹.

Хоёр. Төлбөрийн арга

2.1 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан "Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам"-ын 2 дугаар бүлэгт заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг "Тохиолдолд суурилсан төлбөрийн арга"-аар тооцно.

2.2 "Тохиолдолд суурилсан төлбөрийн арга" гэдгийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-т² зааснаар ойлгоно.

2.3 "Оношийн хамааралтай бүлэг" нь тохиолдолд суурилсан төлбөрийн аргын нэг хэлбэр бөгөөд өвчин эмгэгийн оношийг эмнэлзүйн хувьд төстэй, өртгийн хувьд ойролцоо байдлаар нь сонгон багцаж бүлэг үүсгэх, бүлэг бүрийн дундаж өртгийг урьдчилан тооцож, тухайн бүлэг дэх оноштой хамаарал бүхий тусламж үйлчилгээг санхүүжүүлдэг арга юм.

2.4 "Оношийн хамааралтай бүлэг"-ийн төлбөрийн арга нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.4.1 **Оношийн хамааралтай бүлгийн код:** Бүлэг нь тусламж, үйлчилгээний нийтлэг онцлогийг илтгэх 7 хүртэлх цифрээс бүрдсэн кодтой байх бөгөөд кодын орон нь дараах утгыг илэрхийлнэ:

2.4.1.1 эхний 2 орон нь тухайн бүлэгт хамрагдах оношийн үндсэн ангилал буюу эрхтэн системийн бүлгийн дугаарыг;

2.4.1.2 дараагийн 3 орон нь тухайн бүлэгт орсон оношийн эмнэлзүйн төстэй байдлыг;

2.4.1.3 сүүлийн 2 орон нь тухайн тусламж, үйлчилгээний төрлийг.

¹ Энэхүү төлбөрийн аргыг анхан шатлалын тусламж үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тогтооход ашиглахгүй.
² "Тохиолдолд суурилсан төлбөрийн арга" гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тохиолдол бүрээр зардлыг урьдчилж багцлан тооцож санхүүжүүлэхийг хэлнэ.



2.4.2 **Тухайн бүлэгт хамаарах өвчин эмгэгийн оношийн харсаалт:** Бүлэгт эмнэлзүйн болон өртгийн хувьд ойролцоо оношуудыг жагсаан оруулсан байна. Жилд 20-оос доош удаа тохиолдсон өвчин эмгэгийг эмнэлзүйн болон өртгийн хувьд ойролцоо эсэхийг үл харгалзан нэгтгэж "Ангилалдаагүй бусад" гэсэн бүлэгт хамааруулна.

2.4.3 **Өртгийн жин:** Тухайн оношийн хамааралтай бүлгийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлох индекс бөгөөд тухайн бүлэгт хамаарах тусламж, үйлчилгээний дундаж өртгийг нийт бүлгүүдийн дундаж өртөгт харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно. Өртгийн жин нь бүлэг бүрээр ялгаатай байна.

2.4.4 **Суурь тариф:** ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний өртгийн судалгаа, бодлогын тохируулгын өөрчлөлт, эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл зэрэгт үндэслэн тусламж, үйлчилгээний төрлөөр тодорхойлох ба дараах хэмжээтэй байна:

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Суурь тариф (төгрөг)
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	909,500
2	Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ	32,100
3	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	130,000
4	Яаралтай тусламж, үйлчилгээ	90,950
5	Түргэн тусламж, үйлчилгээ	48,150
6	Телемедицин	53,500
7	Өдрийн эмчилгээ, үйлчилгээ	240,000
8	Өдрийн мэс засал	430,000
9	Бусад өдрийн эмчилгээ	58,850
10	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	700,000
11	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	880,000
12	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	450,000

2.5 Оношийн хамааралтай бүлэгт багтах өвчин эмгэгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг бүлгийн суурь тариф болон өртгийн жингийн үржвэрээр тодорхойлно.

$$Z_{\text{ош}} = C_{\text{ош}} * K_{\text{ош}}$$

Энд,
 $Z_{\text{ош}}$ – тухайн бүлэгт хамаарах оношийн нэг тохиолдлын нийт төлбөрийн хэмжээ
 $C_{\text{ош}}$ – суурь тариф
 $K_{\text{ош}}$ – холбогдох оношийн хамааралтай бүлгийн өртгийн жин

Гурав. Суурь тарифыг өөрчлөх

3.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн үед заавал шинэчилнэ:

3.1.1 албан ёсны статистикаар жилийн инфляцийн сүүлийн хоёр жилийн нийлбэр 10 хувиас давсан;

3.1.2 эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн;

3.1.3 америк долларын төгрөгтэй харьцах ханш сүүлийн 2 жилийн дотор 20 ба түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн;

3.1.4 эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн тогтолцооны үнэлгээ болон тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанар, үр дүнд хийсэн судалгаагаар суурь тарифыг өөрчлөх шаардлагатай нь нотлогдсон.

3.2 Суурь тарифыг өөрчлөлттэй уялдуулан оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг өөрчлөхгүй байж болно.

3.3 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь суурь тарифыг өөрчлөх шаардлагатай эсэхэд жил бүр дүн шинжилгээ хийнэ.

--oOo--

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн 01 дүгээр тогтоолын гуравдугаар хэсэрт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖ ТОХИОЛДЛЫГ ТООЦОХ, ТОХИОЛДЛЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.10, 9.1.11, 9.1.13 -д заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.8, 24.6.10-т заасан төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээ (цаашид "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэх")-ний төрлийг тогтоох, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ)-тай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагаас иргэн, даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг ЭМД-ын сан болон төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах зориулалтаар эрүүл мэндийн даатгалын санд улсын төсвөөс шилжүүлж нэгтгэсэн сангаас санхүүжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн байгууллага (ЗМБ) нь иргэнд энэхүү журмын 2.5.1, 2.9, 2.10, 2.11-т зааснаас бусад тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрдээ тусламж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн болон дууссан хугацааг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбосон хурууны хэз уншигч төхөөрөмжөөр хэрэв тийм боломжгүй бол иргэний регистрийн дугаараар бүртгэж, баталгаажуулна.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний удирдамжид зааж өвчний түүх болон холбогдох бүртгэлд бичигдсэн бөгөөд Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, мас заслын хэрэгсэл, протез, ортопедийг зайлшгүй шаардлагаар иргэнээр авахуулсан тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллагаас сонгон шалгаруулалт зохион байгуулж худалдан авсан үнээр, хэрэв тухайн эмийг сонгон шалгаруулалтаар аваагүй тохиолдолд худалдан авсныг нь нотлох e-баримт эсхүл санхүүгийн баримт дахь үнээр тус тус тооцож иргэнд заавал буцаан олгоно.

Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл

2.1. Амбулаторийн тусламж, үйлчилгээ:

- 2.1.1. амбулаторийн үзлэг;
- 2.1.2. амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц;
- 2.1.3. амбулаториор хийгдэх ажилбар;

- 2.1.4. шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 2.1.5. амбулаторийн хяналтын үзлэг;
 2.1.6. жирэмсийн хяналтын багц;
 2.1.6.1. хэвийн явцтай жирэмсний хяналтын багц;
 2.1.6.2. эрсдэлтэй жирэмсний хяналтын багц;
 2.2 Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ;
 2.3 Өдрийн эмчилгээ:
 2.3.1. өдрийн мэс засал;
 2.3.2. хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ;
 2.3.3. хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ;
 2.3.4. өдрийн эмийн эмчилгээ;
 2.4 Диализын тусламж, үйлчилгээ;
 2.5 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:
 2.5.1. эрчимт эмчилгээ;
 2.5.2. эмийн эмчилгээ;
 2.5.3. мэс засал;
 2.5.4. эрхтэн шилжүүлэх мэс засал;
 2.5.5. хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ;
 2.6 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;
 2.7 Саргэн засах тусламж, үйлчилгээ:
 2.7.1. амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 2.7.2. өдрийн эмчилгээ;
 2.7.3. хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
 2.8 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ:
 2.8.1. амбулаторийн тусламж, үйлчилгээ;
 2.8.2. өдрийн эмчилгээ;
 2.8.3. хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
 2.9 Яаралтай тусламж:
 2.9.1. ерөнхий мэргэжлийн яаралтай тусламж;
 2.9.2. гэмтлийн яаралтай тусламж;
 2.10 Түргэн тусламж:
 2.10.1. ойрын дуудлага;
 2.10.2. алсын дуудлага;
 2.11. Телемедициний тусламж, үйлчилгээ.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагад ЭМД-ын сангаас олгох тусламж, үйлчилгээний нийт зардлын санхүүжилт

- 3.1. ЭМД-ын сангаас эрүүл мэндийн байгууллагад олгох нийт санхүүжилт нь энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан тусламж, үйлчилгээний төрөл тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.
 3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтын үйл ажиллагааны хүрээнд тусламж үйлчилгээтэй холбоотой зөрчил илэрсэн бол



тухайн нэгж тохиолдлын санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.

3.3. Эрүүл мэндийн байгууллагын ЭМД-ын сангаас санхүүжих нийт тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нь ЭМДЕГ-тай байгуулсан тухайн жилийн гэрээнд тусгагдсан тусламж, үйлчилгээний тоо хэмжээгээр хязгаарлагдана.

3.4. Эрүүл мэндийн байгууллагад иргэнд үзүүлсэн дараах тусламж, үйлчилгээний зардлыг тухайн иргэн эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран ЭМД-ын сангаас бүрэн санхүүжүүлнэ. Үүнд:

- 3.4.1. яаралтай тусламж;
 3.4.2. түргэн тусламж;
 3.4.3. жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал;
 3.4.4. халдварт өвчний оношилгоо, эмчилгээ;
 3.4.5. сэтгэцийн эмгэгийн зарим тусламж, үйлчилгээ.

3.5. Энэхүү журмын 3.4-т зааснаас бусад тохиолдолд зөвхөн эрүүл мэндийн даатгалтай иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ.

3.6. ЭМДЕГ нь тухайн эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр олгож болох бөгөөд энэ тохиолдолд үлдэгдэл санхүүжилтийг үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтын үр дүнг үндэслэн, гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ.

3.7. Эрүүл мэндийн байгууллагын үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрт ЭМД-ын сангаас олговол зохих нийт санхүүжилт нь энэ журмын 3.6-д заасан урьдчилгаа төлбөрөөс бөгөөд тохиолдолд илүү олгосон үр дүнгийн үндэслэлээр иргэдийн урьдчилгааны дүнгээс суутган шилжүүлж тооцно.

3.8. Хэрэв жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн эрүүл мэндийн байгууллагад олгосон нийт санхүүжилт нь тухайн эрүүл мэндийн байгууллагын үзүүлсэн тусламж, үйлчилгээнд олговол зохих төлбөрөөс илүү гарсан тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэлийг хийж, тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдэж, санхүүгийн тайланд тусгана. Илүү төлсөн төлбөрийг гэрээнд заасны дагуу дараа жилийн санхүүжилтээс суутгах, эсхүл буцаан төлүүлэх бусад арга хэмжээг авна.

Дөрөв. Иргэний хариуцан төлөх төлбөр

4.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан Монгол улсын иргэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан "ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай

бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ-д заасан иргэний хариуцан төлөх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө.

4.2 Дараах иргэн энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан 67-69, 223, 224, 238, 239, 592 дугаар оношийн хамааралтай бүлэг, 99 дүгээр оношийн хамааралтай бүлгийн U07 оношоос бусад оношийн хамааралтай бүлгийн иргэний хариуцан төлөх төлбөрөөс чөлөөлөгдөнө:

4.2.1. тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн /Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвр, тэтгэмжийн тухай хуулийн 2.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дахь заалтын дагуу тэтгэвр авагчид/;

4.2.2. нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай иргэн;

4.2.3. хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

4.2.4. хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нэр хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;

4.2.5. ял эдэлж байгаа ялтан;

4.3. Монгол улсын 0-18 насны хүүхэд энэхүү журмын 4.1-д заасан иргэний хариуцан төлөх төлбөрөөс чөлөөлөгдөнө.

4.4. Нийт иргэн, даатгуулагч энэхүү журмын 4.1-д заасан иргэний хариуцан төлөх төлбөрөөс (энэхүү журмын 4.2, 4.3-т зааснаас бусад тохиолдолд) гадна дараах нэмэлт төлбөрийг өөрөө хариуцан төлнө:

4.4.1. Энэхүү журмын 4.5-т заасан шаардлагыг хангасан ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулсан гэрээгээр энэхүү журмын 4.6-т заасан шаардлагыг хангасан тусламж үйлчилгээний хувьд үнийн тохиролцоо хийж, гэрээнд тусгасан тариф болон тухайн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээний зөрүү төлбөр;

4.4.2. Даатгуулагч "Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц"-ын тусламж, үйлчилгээг бүрэн аваагүй буюу өөрийн буруугаас даатан үзлэгт ороогүй бол дараагийн удаад энэ журмын 3.4-т зааснаас бусад тусламж, үйлчилгээ авах тохиолдолд тухайн тусламж үйлчилгээний нийт зардлын 25 хувийг;

4.4.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний өртгийн тооцоолонд ороогүй, ЭМДЕГ болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан гэрээнд тусгайлан заагдсан, иргэний хусалтийн дагуу үзүүлсэн нэмэлт үйлчилгээний төлбөрийг 100 хувь;

4.4.4. ОХБ-ийн жагсаалтад ороогүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг 100 хувь;

4.4.5. Тухайн жилд 3-аас дээш удаа шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд 4 дэх тохиолдлоос эхлэн төлбөрийг ОХБ-ийн жагсаалтад заасан хэмжээгээр 100 хувь;

4.4.6. Монгол улсын 0-18 насны хүүхдээс бусад иргэн, даатгуулагч хэвтүүлэн эмчлэх 0340141, 0340142 код бүхий "Ихний бусад өвчин" 82, 83 дугаар ОХБ-т хамаарах мээ заслын төлбөрийг 100 хувь;

4.4.7. Жирэмсэн эмэгтэй болон 0-18 насны хүүхдээс бусад иргэн, даатгуулагч хэвтүүлэн эмчлэх Коронавирус халдвар /Ковид-19/-ын U07 оношийн хөнгөн тохиолдлоор хэвтэн эмчлүүлсэн бол төлбөрийг 100 хувь;

4.4.8. Эмчийн заалт, илгээх бичиггүйгээр иргэн сайн дураараа шатлал алгасан лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан, оношилгоо шинжилгээ /өндөр өртөгтэй болон бусад/ хийлгэсэн тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний зардлыг холбогдох ОХБ-ийн жагсаалтад заасан хэмжээгээр, эсхүл хэрэв тухайн тусламж үйлчилгээ нь ОХБ-ийн жагсаалтад багтдаггүй бол төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-ээр 100 хувь;

4.5. ЭМДЕГ-ын цахим систем болон И-баримтын мэдээллийн сан дахь тухайн ЭМБ-ын өнгөрсөн жил үзүүлсэн тусламж, үйлчилгээний ОХБ тус бүрийн нэгж хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нийт төлбөрийн хэмжээний дунджийг гэрээ байгуулах цаг үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй, ЭМДҮЗ-өөс баталсан ОХБ тус бүрийн нийт төлбөрийн хэмжээтэй харьцуулахад 50 болон түүнээс дээш ОХБ дээр тухайн ЭМБ-ын төлбөрийн хэмжээ нь ЭМДҮЗ-өөс баталсан ОХБ тус бүрийн нийт төлбөрийн хэмжээнээс өндөр байгаа ЭМБ-тай энэхүү журмын 4.6-д заасан шаардлагыг хангасан тусламж, үйлчилгээний тарифыг гэрээгээр тохиролцоно.

4.6. Дараах шаардлагыг бүхэлд нь эсхүл аль нэгийг нь хангасан тусламж, үйлчилгээний тарифыг гэрээгээр тохиролцоно. Үүнд:

4.6.1. Даатгуулагчийн амь насыг аврах, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ хэдий ч хүртээмж нь нэн хязгаарлагдмал, хүртээмжийг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээ;

4.6.2. Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад багтсан өвчин эмгэгийн эмчилгээ;

4.6.3. Даатгуулагчид нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлсэн бөгөөд уг технологийг даатгах зардал нь ЭМД-ын тусламж, үйлчилгээний тарифт шингээгүй тохиолдолд;

4.6.4. Тухайн тусламж, үйлчилгээ тухайн ЭМБ-аас өөр ЭМБ үзүүлдэггүй бөгөөд тухайн тусламж, үйлчилгээний өртөг нь ЭМДҮЗ-ийн баталсан төлбөрийн хэмжээнээс давсан тохиолдолд;


4.7. Монгол улсын хууль, Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй даатгуулагч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа тухайн тусламж, үйлчилгээний нийт төлбөрийн хэмжээний 80 хувьтай тэнцэх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө. Монгол улсаас бусад улстай байгуулсан Нийгмийн хамгааллын гэрээ, хэлэлцээрт эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудлыг тусгасан тохиолдолд тухайн гэрээ, хэлэлцээрийн зохицуулалтыг баримтална.




Тав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, тэлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх


5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцон, ЭМД-ын сангаас санхүүжүүлэхэд дараах удирдамжийг баримтална.

Тусламж, үйлчилгээний төрөл	Нэгж тохиолдлыг тооцох	Тохиолдлын тоог хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдолд хамаарах зардлын бүрэлдэхүүн
1. Амбулаторийн тусламж, үйлчилгээ			
Амбулаторийн үзлэг	Дараах тохиолдлуудыг амбулаторийн үзлэг болон амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын нэгж тохиолдлын тоонд тооцож, ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ. 1. Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн өвчтөн шилжүүлэх бичгээр лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиникээс амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдол;		Амбулаторийн үзлэгийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн нэг удаагийн үзлэг, зөвлөгөө, түүнд шаардагдах эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн болон холбогдох бусад зардал хамаарна.
Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц	2. Нэгдсэн эмнэлэг, клиникийн эмчийн өвчтөн шилжүүлэх бичгийн дагуу өөр нэгдсэн эмнэлэг, клиник эсхүл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгээс амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдол; 3. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгийн эмчийн өвчтөн шилжүүлэх бичгийн дагуу өөр төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгээс амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдол; 4. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнд тухайн эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн тусламж, үйлчилгээ авах нэмэлт шаардлага гарсан тохиолдол;	1. Амбулаторийн эмч нь даатгуулагчийн оношийг тодорхойлох зорилгоор ОХБ-ийн жагсаалт болон ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнээс бусад оношилгоо, шинжилгээг удаа дараа хийх, улмаар давтан үзлэгийг удаа дараа хийсэн нь "Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц"-ын тохиолдлын тоог нэмэх үндэслэл болохгүй.	Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчийн анхан болон давтан үзлэг, зөвлөгөө, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, онош тодруулах зорилгоор хийсэн энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралт болон ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнээс бусад оношилгоо, шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.

	<p>Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>1. Даатгуулагч нь өвчний учир, эмчийн заалтаар тухайн лавлагаа шатлалын нэг эрүүл мэндийн байгууллагад 4 хүртэлх амбулаторийн кабинетаар үйлчлүүлж, амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас дараах байдлаар санхүүжүүлнэ.</p> <p>Үүнд:</p> <p>1.1 Даатгуулагч нь тухайн эрүүл мэндийн байгууллагын нэг амбулаторийн кабинетаар үйлчлүүлсэн бол эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг 100 хувь олгох бол харин хоёр дахь амбулаторийн кабинетын үзлэгт 70 хувь, гурав дахь амбулаторийн кабинетын үзлэгт 50 хувь, дөрөв дэх амбулаторийн кабинетын үзлэгт 30 хувиар тус тус тооцон санхүүжүүлнэ.</p> <p>2. Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын тусламж, үйлчилгээг даатгуулагчид цогц байдлаар үзүүлсэн эсэхээс хамааран төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:</p> <p>2.1 Өвчний учир хийх амбулаторийн анхан болон давтан үзлэгийг, оношилгоо шинжилгээний хамт цогц байдлаар үзүүлсэн тохиолдлыг "Амбулаторийн үзлэг, оношилгоо шинжилгээний багц"-ын нэг тохиолдол гэж тооцон, амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын төлбөрийн хэмжээгээр буюу 100 хувь санхүүжүүлнэ.</p> <p>2.2 Амбулаторийн анхан үзлэг болон холбогдох оношилгоо, шинжилгээ хийгдсэн боловч оношилгоо, шинжилгээний дараах давтан үзлэг хийгдээгүй тохиолдлыг санхүүжүүлэхдээ амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын төлбөрийн хэмжээний 70 хувиар тооцон санхүүжүүлнэ.</p> <p>3. Эрүүл мэндийн байгууллага нь тухайн лавлагаа шатлалын өөр эрүүл мэндийн байгууллагад хийлгэсэн оношилгоо, шинжилгээг даатгуулагчид давтан хийсэн тохиолдолд оношилгоо, шинжилгээний зардлыг давхардуулан санхүүжүүлэхгүй, амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын төлбөрийн хэмжээний 50 хувиар тооцож санхүүжилтийг олгоно.</p> <p>4. Даатгуулагч амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц хийлгээний дараа 14 хоногийн дотор эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын төлбөрийн хэмжээний 50 хувиар тооцож санхүүжилтийг олгоно. Учир нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардалд оношилгоо, шинжилгээний зардал багтсан.</p>	
<p>Амбулаториор хийгдэх ажилбар (хатиг, буглаа нээх, эрүү нүүрний жижиг ажилбар гэх мэт)</p>	<p>Амбулаторийн хийгдэх ажилбарт амбулаторийн нөхцөлд хийсэн жижиг-ажилбар эсхүл мэс ажилбар хийсэн тохиолдлыг тооцно. Даатгуулагчийн хийлгэсэн "Амбулаториор хийгдэх ажилбар" бүрийг нэг тохиолдол хэмээн гооцож санхүүжүүлнэ.</p>		<p>Амбулаториор хийгдэх ажилбарын зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, мэс ажилбар, шархны анхан болон давтан цэцэглээ, боолт, эмчилгээ, сувилгаа, нэг удаагийн хэрэгсэл болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ</p>	<p>Даатгуулагч өвчний учир шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээгээр дагнасан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага болон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, төрийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт үзүүлэн шүдний цогц тусламж, үйлчилгээ авсан тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг жилд даатгуулагчийн нийт 3 хүртэлх шүдний цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ.</p>	<p>Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд шүд, амны хөндийн мэргэшлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, тухайн шүдний бүрэн эмчилгээ болон холбогдох бусад зардал хамаарна.</p>


	Даатгуулагчийн нэг шүдийг бүрэн эмчлэх бүхий л тусламж, үйлчилгээг цогц тусламж, үйлчилгээ хэмээн үзнэ.		
Амбулаторийн хяналтын үзлэг	Эмчийн заалтаар хийгдэж буй "Амбулаторийн хяналтын үзлэг" бүрийг нэг тохиолдол хэмээн тооцно.		Амбулаторийн хяналтын үзлэгийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралт болон ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнээс бусад оношилгоо, шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиникийн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмчийн хяналтад байх шаардлагатай иргэний амбулаторийн байнгын хяналтын үзлэг (эрхтэн шилжүүлэх мэс засал, хорт хавдрын эмчилгээний дараах хяналт, сэтгэцийн болон хүүхдийн эмгэгийн байнгын хяналт гэх мэт) болон анхан шатны эмчийн заалтаар лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиникт хийх амбулаторийн хяналтын үзлэгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 300021 бүлэгт заасан U07 оношоор Ковид-19 өвчний халдварын улмаас лавлагаа шатлалын амбулаторийн хяналтын тусламж, үйлчилгээ авсан тохиолдлыг санхүүжүүлэх бөгөөд харин Ковид-19 өвчний дараах нөхцөл байдлыг амбулаторийн хяналтын бүлгүүдийн холбогдох Z бүлгийн кодоор үүссэн өвчний хамт давхар кодолсны үндсэн дээр санхүүжүүлнэ.	
А.Хэвийн явцтай жирэмсний хяналтын багц	Даатгуулагчийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад жирэмсний хяналтын хугацааны туршид хийлгэх цогц хяналтыг жирэмсний хяналтын нэг тохиолдол гэж тооцно.	Хэвийн явцтай жирэмсний хяналтын багцын зардлын бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох журам, тушаалаар баталсан "Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлол"-ын дагуу лавлагаа шатлалд хийгдэх эмчийн үзлэг, зөвлөгөө, сорил, оношилгоо, шинжилгээний болон холбогдох бусад зардал хамаарна.	
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	Хэвийн явцтай жирэмсний хяналтын багцын санхүүжилтийг жирэмсний хяналтын үе шаттай уялдуулан дараах байдлаар хэсэгчлэн санхүүжүүлнэ. Үүнд: 1. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 12 дугаар долоо хоног дотор хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ хийгдсэний дараа - 35 % 2. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 18-22 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо хийгдсэний дараа - 15 % 3. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 28 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ хийгдсэний дараа - 10 % 4. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 32 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо хийгдсэний дараа - 30 % 5. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 38 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг хийгдсэний дараа - 10 %	
Б.Эрсдэлтэй жирэмсний хяналтын багц	Даатгуулагчийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад жирэмсний хяналтын хугацааны туршид хийлгэх цогц хяналтыг жирэмсний хяналтын нэг тохиолдол гэж тооцно.	Эрсдэлтэй жирэмсний хяналтын багцын зардлын бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн сайдын холбогдох журам, тушаалаар баталсан "Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлол"-ын дагуу лавлагаа шатлалд хийгдэх эмчийн үзлэг, зөвлөгөө, сорил, оношилгоо, шинжилгээний болон холбогдох бусад зардал хамаарна.	

	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт</p> <p>баримтлах</p>	<p>Эрсдэлтэй жирэмсний хяналтын багцын санхүүжилтийг жирэмсний хяналтын үе цагтай уялдуулан дараах байдлаар хэсэгчлэн санхүүжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 12 дугаар долоо хоног доторх хугацаанд хийхээр товлосон оношилгоо шинжилгээ-г хийсний дараа - 55 % 2. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 18-22 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо хийгдсэний дараа - 10 % 3. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 28 дугаар долоо хоногт хийгдэх оношилгоо, шинжилгээ хийгдсэний дараа - 5 % 4. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 32 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо хийгдсэний дараа - 20 % 5. Жирэмсний 38 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг хийгдсэний дараа - 5 % 6. Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жирэмсний 39-40 дүгээр долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг хийгдсэний дараа - 5 %
<p>Жирэмсний хяналтын багцыг баримтлах зохицуулалт</p>		<ol style="list-style-type: none"> 1. Жирэмсэн эмэгтэй нь жирэмсний хяналт хийлгэх лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, клиникийг сонгох боломжтой бөгөөд зардлын төлбөрийг жирэмсний хяналт хийсэн эрүүл мэндийн байгууллага руу санхүүжүүлнэ. 2. Жирэмсний хяналт нь ямар нэг шалтгааны улмаас жирэмсний хяналтын тодорхой хугацаанд тасалдсан тохиолдолд жирэмсний хяналт зогссон тухайн үе шат хүртэлх зардлын төлбөрийг тусламж, үйлчилгээ үзүүлсэн байгууллагад олгоно. 3. Жирэмсэн эмэгтэй нь "Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлон"-ыг бүрэн мөрдөлдүй, хяналтын зарим, үзлэг оношилгоог таслан, дараагийн үзлэг оношилгоонд хамрагдсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээний 70 хувийг олгоно. 4. Жирэмсэн эмэгтэй нь жирэмсний хяналтын явцад хэвийн явцтай жирэмслэлтээс эрсдэлтэй жирэмслэлт гэж үнэлэгдсэн тохиолдолд тухайн цаг мөчөөс эхлэн эрсдэлтэй жирэмсний үзлэг, оношилгоо шинжилгээний оношийн хамааралтай бүлгийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ. 5. Жирэмсэн эмэгтэйд үзүүлсэн жирэмслэлттэй холбоогүй боловч эмчийн заалтаар үзүүлсэн, жирэмсний хяналтын багцад ороогүй бусад төрлийн тусламж, үйлчилгээний зардлыг тухайн оношийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ. 6. Жирэмсний 12 дугаар долоо хоногт хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээг жирэмсний 2-13 дугаар 7 хоногт хийсэн тохиолдолд, бусад жирэмсний хяналтын үе шатанд хийгдэх эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээг товлолын хугацаанаас +6,6 хоногт хийсэн тохиолдолд тухайн товлолын хугацаанд олгох санхүүжилтийн дүнгээр санхүүжүүлнэ. Уг зөвшөөрөгдсөн хугацаанаас өөр хугацаанд хийсэн жирэмсний хяналтын үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлыг санхүүжүүлэхгүй.
<p>Жирэмсний хяналтын багцтай холбогдох бусад зохицуулалт</p>		<ol style="list-style-type: none"> 1. Жирэмсний хяналтад Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан холбогдох тушаал шийдвэрийг мөрдөх бөгөөд энэхүү журам нь зөвхөн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх жирэмсний хяналтын үзлэгийг санхүүжүүлэхэд мөрдөгдөнө. 2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь жирэмсний хяналтыг холбогдох журмын дагуу хийх бөгөөд үүнтэй холбогдох зардал нь энэхүү журмаар зохицуулагдахгүй.
<p>Нийт амбулаторийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд баримтлах нийтлэг зохицуулалт</p>		<ol style="list-style-type: none"> 1. Дараах тохиолдлоос бусад тохиолдолд анхан болон лавлагаа шатлалын эмчийн илгээх бичигтэй амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдлыг ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ. Илгээх бичиг шаардахгүй тохиолдлууд: <ol style="list-style-type: none"> 1.1 Халдварт өвчний тусламж, үйлчилгээ 1.2 Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ 1.3 Чих, хамар, хоолойн тусламж, үйлчилгээ 1.4 Хорт хавдар, осол гэмтлийн тусламж, үйлчилгээ 1.5 Арьс, харшлын тусламж, үйлчилгээ



	<p>1.6 Эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн байгууллагад хандахад нөлөөлөх хүчин зүйлс</p> <p>1.7 Сэтгэц, зан үйлийн эмгэгийн тусламж, үйлчилгээ</p> <p>1.8 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ</p> <p>1.9 Сэргээн засах тусламж, үйлчилгээ</p> <p>1.10 Амбулаториор хийгдэх мэс ажилбар</p> <p>2. Амбулаторийн үзлэгийг утсаар үзүүлсэн бол амбулаторийн үзлэгийн тохиолдолд тооцоггүй, санхүүжүүлэхгүй.</p>
<p>2. Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ</p>	
<p>Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ</p>	<p>Даатгуулагчийн тухайн сард эмчийн заалтаар лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад нэг оношийн хүрээнд хийлгэсэн ижил төрлийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тохиолдлуудыг багцлан нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>1. Өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ хийлгэсний дараа даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх тасаг руу илгээн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд тухайн өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй. Учир нь хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд шаардлагатай өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний зардал багтсан.</p> <p>Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчийн дүгнэлт, урвалж, бодис, лабораторийн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>1. Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний нэг тохиолдлыг санхүүжүүлэхдээ ОХБ-ийн жагсаалтад багтаагдсан холбогдох өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ болон ЭМДЕГ-ын даргын баталсан өндөр өртөг бүхий шинжилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг баримтална.</p> <p>2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь нэгдсэн эмнэлэг, клиникт хийсэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг зайлшгүй тохиолдолд давтан хийх бөгөөд ЭМДЕГ-н Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас давтан хийсэн үндэслэлийг хянасны үр дүнд тус тохиолдлыг санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>3. Зайлшгүй тохиолдолд эмчийн заалтаар MRI болон КТ оношилгоог тодосгогч бодис ашиглан хийж болох бөгөөд тодосгогч бодисын нийт төлбөрийн хэмжээ нь 165,000 төгрөг, үүнээс 70 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 30 хувийг иргэн тус тус хариуцан төлнө.</p> <p>4. ЭМДЕГ нь нэг даатгуулагчид нэг оношийн хүрээнд хийсэн ижил төрлийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ хийсэн нэхэмжлэлийг 2 өөр байгууллагаас хүлээн авсан тохиолдолд чанарын үнэлгээнд үндэслэн, аль нэг байгууллагад нь л санхүүжилтийг олгоно.</p>
<p>Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээтэй холбогдох бусад зохицуулалт</p>	<p>1. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг тухайн оношийн хүрээнд хийгдэх ерөнхий оношилгоо, шинжилгээгээр онош нь тодрох боломжгүй, нарийн оношилгоо хийлгэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвхөн эмчийн заалтаар хийнэ.</p> <p>2. Өндөр өртөгтэй шинжилгээний багцад хамаарах шинжилгээний жагсаалтыг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлах бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхдээ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г баримтална.</p> <p>3. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэг хийсэн эмчийн заалтаар хийсэн өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээний тохиолдол бүрийг ЭМДЕГ-н Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас тухайн өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ тухайн даатгуулагчид зайлшгүй шаардлагатай эсэх, тодосгогч бодис ашиглах шаардлагатай эсэх болон бусад төрлийн хяналт хийсний үндсэн дээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p>





4. ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар тухайн эрүүл мэндийн байгууллага нь иргэнд шаардлагагүй тохиолдолд өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ хийсэн, эсхүл шаардлагагүй тохиолдолд тодосгогч бодис ашигласан нь тогтоогдвол уг тохиолдлын зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллага нь иргэнээс авсан иргэний хариуцан төлсөн төлбөрийг 100 хувь буцаан олгоно.

5. Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник нь хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас өөрийн үйлчлүүлэгчид хийх шаардлагатай өндөр өртөг бүхий шинжилгээг өөр эрүүл мэндийн байгууллагаар хийлгэсэн тохиолдолд оношилгоо, шинжилгээний төлбөрийг ЭМДЕГ үндсэн үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад нэгдсэн эмнэлэг, клиникт шилжүүлэх бөгөөд эмнэлгүүд төлбөр тооцоогоо эмнэлэг хоорондын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэнэ.

6. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний явцад тухайн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүйн улмаас иргэнийг өндөр өртөг бүхий оношилгоо шинжилгээ хийлгэхээр өөр эрүүл мэндийн байгууллага руу илгээсэн тохиолдолд төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллага бүрэн хариуцаж, оношилгоо шинжилгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагад, эсхүл даатгуулагчид төлбөрийн баримтыг үндэслэн төлнө.

3. Өдрийн эмчилгээ

<p>Өдрийн мэс засал</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагад мэс засал хийлгэж, 24 цагийн дотор эмнэлгээс гарсан тохиолдлыг өдрийн мэс заслын нэг тохиолдолд тооцно.</p>	<p>Даатгуулагчид өдрийн мэс засал хийсний дараа эмнэлгүүн шаардлагаар эмнэлэгт хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн тухайн мэс засал хийлгэсэн оношийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ. Нэг оношоор өдрийн мэс засал, хэвтүүлэн эмчлэх мэс заслыг давхардуулан санхүүжүүлэхгүй</p>	<p>Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, мэс засал, мэс ажилбар, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопед (өндөр үнэ бүхий болон бусад), ороох боох материал, сэргээн засах эмчилгээ, сувилгахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ</p>	<p>Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээг хийсэн эмчилгээ нэг бүрийг нэг тохиолдол хэмээн тооцно.</p>		<p>Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, туршид хэрэглэгдэх химийн тариа, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилгахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ</p>	<p>Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээнд авсан удаа бүрийг нэг тохиолдол гэж тооцож нийт туяа эмчилгээнд орсон хоногийн тоогоор үржүүлж санхүүжүүлнэ.</p>		<p>Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, тусламж, үйлчилгээ үзүүлж буй үед ашиглагдах туяа эмчилгээний эм тариа, эмнэлгийн хэрэгслийн зардал, сувилгахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>1. Хэрэв тухайн даатгуулагчид хорт хавдрын туяа болон химийн өдрийн эмчилгээг нэгэн зэрэг хавсран хийсэн тохиолдолд 2 эмчилгээг тус бүрд нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 2. Хэрэв тухайн даатгуулагчид хорт хавдрын хими эмчилгээ болон химийн өдрийн бай эмчилгээг нэгэн зэрэг хавсран хийсэн тохиолдолд 2 эмчилгээг тус бүрд нь эрүүл мэндийн даатгалын сангаас тохиолдлоор санхүүжүүлнэ. 3. Даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэх үед зайлшгүй шаардлагаар хорт хавдрын туяа эмчилгээ хийсэн тохиолдолд хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардал дээр нэмж, хорт хавдрын туяаны</p>		

		өдрийн эмчилгээний зардлыг холбогдох туяа эмчилгээний төлбөрийн хэмжээг баримтлан тохиолдлын тоогоор нэмж санхүүжүүлнэ.	
Өдрийн эмийн эмчилгээ	Өдрийн эмийн эмчилгээ нь нэг оношоор 5-аас доошгүй хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нэг багц гэж тооцно.	Даатгуулагчид өдрийн эмийн эмчилгээ үзүүлж байх хугацаанд тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.	1. Өдрийн эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээ, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, сэргээн засах эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна. 2. Тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан 616 дугаар оношийн хамааралтай бүлгийн Иод 131 эмчилгээнд өвчний түүх нээж 5 хоног эмчлэх шаардлагагүй тул тухайн тусламж, үйлчилгээг холбогдох эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу үзүүлсэн эсэхэд хяналт тавьж санхүүжилтийг олгоно.
4. Диализын тусламж, үйлчилгээ			
Диализын тусламж, үйлчилгээ	Диализын эмчилгээ тус бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.		Диализын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, диализын шингэн, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо шинжилгээ, сувилахуйн зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	1. Даатгуулагч нь хэвтүүлэн эмчлэх эмийн тусламж, үйлчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээ авах хугацаанд диализ эмчилгээнд хамрагдсан тохиолдолд диализын эмчилгээний зардлыг нь диализ эмчилгээний төлбөрийн хэмжээг баримтлан тохиолдлын тоогоор тооцож, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардал дээр нэмж олгоно. 2. Өдрөөр хийлгэх диализ болон диализын тусламж, үйлчилгээний хяналтаас өөр, цаг товлосон амбулаторийн үзлэгийг холбогдох оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн хэмжээгээр тусад нь санхүүжүүлнэ.	
5. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ			
Эрчимт эмчилгээ	1. Даатгуулагч нь эмчийн заалтаар, зайлшгүй шаардлагаар эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлсэн тохиолдол (ангиографийн мэс заслын дараа хяналт хийх зорилгоор иргэнийг эрчимт эмчилгээний тасаг хянасан тохиолдлоос бусад) тус бүрийг эрчимт эмчилгээний нэг тохиолдол гэж тооцно.	1. Ангиографийн мэс заслын дараа хяналт хийх зорилгоор иргэнийг эрчимт эмчилгээний тасагт богино хугацаагаар хянасан тохиолдлыг эрчимт эмчилгээний тохиолдолд тооцохгүй. 2. Даатгуулагч эрчимт эмчилгээний тасгаас хэвтүүлэн эмчлэх тасаг руу шилжих, улмаар дахин эрчимт эмчилгээний тасаг руу шилжсэн тохиолдлыг эрчимт эмчилгээний нэг тохиолдол гэж тооцно.	Эрчимт эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, эрхтэн орлуулах эмчилгээ, цус цусан бүтээгдэхүүн, эмчийн үзлэг, мэс заслын тусламж, бүх төрлийн оношилгоо шинжилгээний зардал (өндөр өртөгтэй болон бусад), сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.
Эрчимт эмчилгээг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт		1. Иргэн яаралтай тусламжийн тасгаас эрчимт эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх тасаг руу шууд шилжиж, эрчимт эмчилгээ, мэс засал, эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд зөвхөн холбогдох эрчимт эмчилгээ, мэс засал, эсхүл эмийн эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас тус бүрд нь санхүүжүүлнэ.	

	<p>2. Даатгуулагч нь нэгдсэн эмнэлэг, клиникийн эрчимт эмчилгээний тасгаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт шилжин ирсэн тохиолдолд нэгдсэн эмнэлэг, клиник болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тохиолдол тус бүрийг эрчимт эмчилгээний нэг тохиолдол гэж тооцно. Энэ тохиолдолд нэгдсэн эмнэлэг, клиникийн эмнэлгийн эрчимт эмчилгээний тохиолдлыг шинж тэмдгийн оношоор, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрчимт эмчилгээний тохиолдлыг үндсэн оношийн эрчимт эмчилгээний төлбөрийн хэмжээгээр тооцон, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p>
<p>Эрчимт эмчилгээтэй холбогдох бусад зохицуулалт</p>	<p>1. Эрчимт эмчилгээний А оношийн хамааралтай бүлгээр хоёр болон түүнээс дээш эрхтэн системийн дутагдалд орж эрчимт эмчилгээ хийлгэсэн тохиолдлыг санхүүжүүлнэ. 2. Эрчимт эмчилгээний В оношийн хамааралтай бүлгээр нэг эрхтэн системийн дутагдалд орж эрчимт эмчилгээ хийлгэсэн тохиолдлыг санхүүжүүлнэ. 3. Эрчимт эмчилгээний үед иргэнээр эм тариа авахуулахыг бүрэн хориглох бөгөөд авахуулсан тохиолдолд энэхүү журмын 1.3-т заасны дагуу төлбөрийг иргэнд баримтыг үндэслэн буцаан олгоно.</p>
<p>Эмийн эмчилгээ</p>	<p>Өвчний учир, эмчийн заалгаар хэвтүүлэн эмчилсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p> <p>1. Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай үйлдэл, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор давтан хэвтүүлэн эмчлүүлсэн нь ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд давтан хэвтэлтийг санхүүжүүлэхгүй. 2. Даатгуулагч эрчимт эмчилгээний тасгаас энгийн тасаг руу шилжин эмчлүүлэх, эсхүл энгийн тасгаас эрчимт эмчилгээний тасаг руу шилжин, улмаар энгийн тасаг руу шилжин эмчлүүлсэн тохиолдлуудад эмийн эмчилгээний болон эрчимт эмчилгээний тус бүр нэг тохиолдол хэмээн үзэж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p> <p>Хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацаанд хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээ (өндөр өртөгтэй болон бусад), уламжлалтын болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна. Жич: "Миелом ба плазмоцитын өмөн"-ийн үеийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд дээр дурдсан нийтлэг зардлуудаас гадна хэвтүүлэн эмчлэх үеийн хими болон туяа эмчилгээний зардал багтсан болно.</p>
<p>Эмийн эмчилгээг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>Иргэн яаралтай тусламжийн тасгаас эрчимт эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх тасаг руу шууд шилжиж, эрчимт эмчилгээ, мэс засал, эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд зөвхөн холбогдох эрчимт эмчилгээ, мэс засал, эсхүл эмийн эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас тус бүрд нь санхүүжүүлнэ.</p>
<p>Эмийн эмчилгээтэй холбогдох бусад зохицуулалт</p>	<p>1. Даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх эмийн тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор тооцож, шилжин хэвтсэн оношийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ. Энэхүү тасаг хооронд шилжсэн шилжилттэй холбоотойгоор энэхүү журмын 4.1-т заасан иргэний хариуцан төлсөн төлбөрийн хэмжээнд зөрүү үүссэн тохиолдолд илүү гарсан зөрүүг эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид буцаан олгох, эсхүл дутуу тохиолдолд зөрүүг даатгуулагч эрүүл мэндийн байгууллагад нөхөн төлнө.</p>

		<p>2. "Ангилдаагүй бусад" оношийн хамааралтай бүлэгт ОХБ-ийн 1-565 дугаар оношийн хамааралтай бүлэгт тусгагүй, бусад оношоор үзүүлэх хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хамаарна.</p> <p>3. 562 дугаар бүлэгт заасан оношийн хамааралтай бүлэгт хамаарах тусламж, үйлчилгээний зардлыг жилд нэг удаа хэвтүүлэн эмчлэхээр тооцож, санхүүжилтийг сар бүрд ногдуулан тооцож олгох бөгөөд сар бүр хэвтүүлэн эмчлүүлж буй иргэний чанар үр дүнд явцын хяналт хийж энэхүү тусламж, үйлчилгээ авч буй иргэнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, хурууны хээ уншуулахыг шаардахгүй.</p> <p>4. Даатгуулагч хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авч байх хугацаандаа амбулаторийн аливаа тусламж, үйлчилгээ, өндөр өртөг бүхий оношилгоо шинжилгээний тусламж, үйлчилгээг өөрийн санаачилгаар авсан тохиолдолд тухайн амбулаторийн тусламж, үйлчилгээ болон оношилгоо, шинжилгээний зардлыг санхүүжүүлэхгүй.</p> <p>5. Хэвтүүлэн эмчлэх 0340141, 0340142 код бүхий "Чихний бусад өвчин" 82, 83 дугаар ОХБ-т хамаарах мэс заслыг Монгол улсын иргэн, 0-18 хүртэлх насны хүүхдэд үзүүлсэн тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. Бусад тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй буюу төлбөрийг иргэн, даатгуулагч өөрөө хариуцан төлж, тус тусламж, үйлчилгээг авна.</p> <p>6. Эмийн эмчилгээний А оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүнд зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн, эмийн эмчилгээ хийсэн тохиолдлыг санхүүжүүлнэ.</p> <p>7. Эмийн эмчилгээний В оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүндэвтэр зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн, эмийн эмчилгээ хийсэн тохиолдлыг санхүүжүүлнэ.</p> <p>8. Жирэмсэн болон 0-18 насны хүүхдийг Ковид-19-ийн U07 оношийн хөнгөн тохиолдлоор хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд хэвтүүлэн эмчлэх 234361 код бүхий "Ангилдаагүй бусад" ОХБ-ээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. Бусад иргэн, даатгуулагч Ковид-19-ийн U07 оношийн хөнгөн тохиолдлоор хэвтүүлэн эмчлүүлсэн тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй бөгөөд төлбөрийг иргэн, даатгуулагч өөрөө хариуцан төлж, тус тусламж, үйлчилгээг авна.</p>
<p>Мэс засал</p>	<p>Даатгуулагчийн өвчний учир, эмчийн заалтаар хийлгэсэн мэс заслын тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно. Мэс заслын тусламж, үйлчилгээний тохиолдол гэж мэс засал, мэдээгүйжүүлэг, сэрээх үйл ажиллагаа цогц тусламж, үйлчилгээг хэлнэ.</p>	<p>Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай байдал, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлсэнээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор давтан мэс засал хийлгэсэн нь ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд давтан мэс заслыг санхүүжүүлэхгүй.</p> <p>Мэс заслын тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд нийт эмчилгээ (мэс засал, мэдээгүйжүүлэг, сэрээх үйл ажиллагаа, эрчимт эмчилгээ)-ний хугацаанд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн, мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлэхэд хэрэглэгдсэн бүхий төрлийн мэс заслын хэрэгсэл, протез, ортопед (өндөр өртөг бүхий болон бусад), мэс заслын багийн зардал, эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, уламжлалт анагаах ухаан, сэргэн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Санхүүжүүлэхэд зохицуулалт</p>	<p>баримтлах</p> <p>1. Алсын дуудлагаар ажилласан эмчийн хийсэн мэс заслын тусламж, үйлчилгээг мэс засал хийгдсэн орон нутгийн эмнэлгийн тохиолдолд бүртгэн, санхүүжилтийг тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага руу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. Харэв алсын дуудлагаар очсон эмч нь тухайн мэс засалд хэрэглэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протез, ортопедийг өөрийн ажиллаж буй эмнэлгээс авч, тухайн мэс засалд ашигласан тохиолдолд</p>

		<p>орон нутгийн эмнэлэг нь мэс заслын хэрэгслийн зардлыг тухайн лавлагаа шатлалын эмнэлгийн тендерийн бодит үнээр нь тооцон, тус лавлагаа шатлалын эмнэлэг рүү шилжүүлнэ.</p> <p>2. Нэг хэвтэлтээр хос эрхтэнд ижил мэс засал хийсэн тохиолдолд тухайн мэс заслын оношийн хамааралтай бүлгийн нийт төлбөрийн хэмжээг 1.6 дахин үржүүлсэн дүнгээр санхүүжүүлнэ. Хэрэв тухайн оношийн хамааралтай бүлэг нь иргэнээс төлөх хамтын төлбөртэй тохиолдолд хамтын төлбөрийн хэмжээг мөн 1.6 дахин үржүүлсэн хэмжээгээр тооцон иргэнээр төлүүлнэ.</p> <p>3. Заалт гаргасан мэс засал нь амжилтгүй болсноос тухайн мэс заслыг өөр аргаар хийсэн тохиолдолд сүүлийнх нь хийгдсэн мэс заслын төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлнэ.</p> <p>4. Даатгуулагчийн мэс заслын тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг мэс заслын тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор тооцож, шилжин хэвтсэн оношийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ. Энэхүү тасаг хооронд шилжсэн шилжилттэй холбоотойгоор энэхүү журмын 4.1-т заасан иргэний хариуцан төлсөн төлбөрийн хэмжээнд зөрүү үүссэн тохиолдолд илүү гарсан зөрүүг эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид буцаан олгох, эсхүл дутуу тохиолдолд зөрүүг даатгуулагч эрүүл мэндийн байгууллагад нөхөн төлнө.</p>
	<p>Бусад зохицуулалт</p>	<p>1. "Ангилалдаагүй бусад" оношийн хамааралтай бүлэгт ОХБ-ийн 1-575 дугаар оношийн хамааралтай бүлэгт тусгагдаагүй, бусад онош, үйлдлээр үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээ хамаарна.</p> <p>2. Мэс заслын эмчилгээ А оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хүнд зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдлыг санхүүжүүлнэ.</p> <p>3. Мэс заслын эмчилгээ В оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хчндэвтэр зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдлыг санхүүжүүлнэ.</p> <p>4. Мэс заслын эмчилгээ С оношийн хамааралтай бүлгээр тухайлсан оношийн эмнэлзүйн хөнгөн зэргийн тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн мэс засал эмчилгээ хийсэн тохиолдлыг санхүүжүүлнэ.</p>
<p>Эрхтэн шилжүүлэх мэс засал</p>	<p>Эмчийн заалтаар хийгдэж буй "Эрхтэн шилжүүлэх мэс засал"-ын тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.</p>	<p>Эрхтэн шилжүүлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд донорын эрхтэн шилжүүлэхийн өмнөх болон дараах эмчилгээний зардал, эрхтэн шилжүүлэх мэс заслын зардал, реципиентийн эрхтэн шилжүүлэх мэс заслын өмнөх болон дараах эмнэлэгт хийгдэх эмчилгээний хугацааны хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн, бүх төрлийн мэс заслын хэрэгсэл, протез, ортопед (өндөр өртөг бүхий болон бусад), эмчийн үзлэг, бүх төрлийн оношилгоо шинжилгээ, уламжлалт анагаах ухааны болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
	<p>Бусад зохицуулалт</p>	<p>1. Донорыг Z өвчний кодоор, реципиентийг холбогдох үндсэн оношоор кодож, бүртгэнэ.</p> <p>2. Амьгүй донороос эрхтэн шилжүүлэх мэс засал хийгдсэн тохиолдолд эрхтэн шилжүүлэх мэс заслын зардал болон реципиентийн эрхтэн шилжүүлэх мэс заслын өмнө болон дараа эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p> <p>3. Амьд донороос эрхтэн шилжүүлэх мэс засал хийсэн тохиолдолд амьд доноо болон</p>

		реципиентийн эрхтэн шилжүүлэн суулгуулах мэс заслын зардал, мэс заслын өмнө болон дараа эмнэлэгт хийгдэх эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.	
Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	Эмчийн заалтаар хийгдэж буй "Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ"-ний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.		Хорт хавдрын дараах хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацаанд хэрэглэсэн хими болон туяа эмчилгээний эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, сувилахуйн болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	1. Хэрэв даатгуулагч эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх үед хорт хавдрын туяа болон хими эмчилгээг хавсран хийсэн тохиолдолд хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими эмчилгээний зардал дээр хэвтүүлэн эмчлэх үед хийсэн туяа эмчилгээний тохиолдлын тоогоор энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээний эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг нэмж санхүүжүүлнэ. 2. Хорт хавдраас бусад өвчнийг хэвтүүлэн эмчлэх явцад зайлшгүй шаардлагаар химийн эмчилгээ хийгдсэн тохиолдолд химийн эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй. Учир нь уг зардал нь тухайн тусламж, үйлчилгээний эмийн эмчилгээний зардалд багтсан болно.	
6. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ			
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	Даатгуулагчид эмчийн заалтаар хийсэн хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ бүрийг нэг тохиолдол хэмээн тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.		Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацаанд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, болон сэргээн засах тусламж, үйлчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	Даатгуулагчид хөнгөвчлөх эмчилгээг үзүүлэх үед эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг үзүүлсэн бол эрчимт эмчилгээний холбогдох оношийн хамааралтай бүлгээр давхар санхүүжүүлнэ.	
7. Сэргээн засах тусламж, үйлчилгээ			
Сэргээн засахын амбулаторийн тусламж, үйлчилгээ	Даатгуулагчийн өвчний учир эмчийн заалтаар лавлагаа шатлалын, сэргээн засах амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.		Сэргээн засах амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд сэргээн засах мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо болон холбогдох бусад зардал хамаарна.
Сэргээн засахын өдрийн эмчилгээ	Даатгуулагчийн өвчний учир, эмчийн заалтаар лавлагаа шатлалын, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.	Даатгуулагчид сэргээн засахын өдрийн тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ.	Сэргээн засахын өдрийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, засал, дасгал, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.

Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Эмчийн заалтаар үзүүлсэн сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдолд тооцно.		Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, засал, дасгал, эм, эмнэлгийн хэрэгсэл, сувилахуйн тусламж, үйлчилгээ, хоолны зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
Бусад зохицуулалт		1. Сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлыг санхүүжүүлэхэд баримтлах дундаж ор хоногийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрлөөс нь хамааруулан ЭМДЕГ ялгавартай тогтооно. 2. Боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний багцад хамаарахгүй.	
8. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ			
Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээ	Даатгуулагчийн өвчний учир болон эрүүл мэндэд нөлөөлж буй бусад нөхцөлийн улмаас эмчийн илгээлтээр лавлагаа шатлалын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцно.		Уламжлалт анагаах ухааны амбулаторийн тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо болон холбогдох бусад зардал хамаарна.
Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээ	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмийн эмчилгээ нь нэг оношоор 5-аас доошгүй хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нэг тохиолдол гэж тооцно.	Даатгуулагчид уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ.	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацаанд хэрэглэгдэх эм, тан, эмнэлгийн хэрэгсэл, эмчийн үзлэг, зөвлөгөө, бариа засал, оношилгоо шинжилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ авах хугацаанд тухайн эмнэлгийн тасаг хооронд шилжсэн тохиолдлыг уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлоор бүртгэж, шилжин хэвтсэн буюу тухайн даатгуулагчийн эмнэлгээс гарах үеийн оношийн хамааралтай бүлгийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг санхүүжүүлнэ.		Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацааны туршид хэрэглэгдэх эм, тан, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо, шинжилгээ, эмчийн үзлэг, зөвлөгөө, бариа засал, сэргээн засах болон сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал, хоолны зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.

Бусад зохицуулалт		ЭМДЕГ-аас уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг тохиолдлыг санхүүжүүлэхэд баримтлах дундаж ор хоногийг тогтооно.	
9. Яаралтай тусламж			
Яаралтай тусламж	Даатгуулагчид үзүүлсэн яаралтай тусламжийн тохиолдол бүрийг нэг тохиолдол гэж тооцон, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.	Яаралтай тусламжийн эрэмбийг тогтоохдоо тухайн иргэний биеийн байдлын бодит бусаар үнэлж, хүнд эрэмбэ тогтоосон нь ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар тогтоогдсон болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй.	Яаралтай тусламжийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, зөвлөгөө, эм, эмнэлгийн хэрэгсэл, бүх төрлийн оношилгоо шинжилгээ (өндөр өртөгтэй болон бусад), эмчилгээ, ажилбар, ажиглалтын зардал болон холбогдох бусад бүх зардал хамаарна.
	Бусад зохицуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Яаралтай тусламжийн зардлыг санхүүжүүлэхдээ Эрүүл мэндийн сайдын яаралтай тусламж, үйлчилгээний эрэмбэ тогтоосон, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийг баримтална. 2. Түргэн тусламжаар ирээд эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт нас барсан тохиолдлыг Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалын дагуу зохих өнгөөр бүртгэж энэ тогтоолын нэгдүгээр хавсралтын яаралтай тусламжийн оношийн хамааралтай бүлгийн ногоон В эрэмбээр санхүүжүүлнэ. 3. Яаралтай тусламж, үйлчилгээ А оношийн хамааралтай бүлгээр яаралтай тусламжийн тухайлсан эрэмбэд тохирсон эмнэлгийн тусламжийг 24 цагийн үйл ажиллагаатай яаралтай тусламжийн тасаг/нэгжид цогцоор нь (яаралтай тусламжийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, хяналт) үзүүлсэн тохиолдлыг санхүүжүүлнэ. 4. Яаралтай тусламж, үйлчилгээ В оношийн хамааралтай бүлгээр яаралтай тусламжийн тухайлсан эрэмбэд тохирсон эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлсэн тохиолдлыг санхүүжүүлнэ. 	
10. Түргэн тусламж			
Түргэн тусламж	Түргэн тусламжийн нэг дуудлагыг нэхэмжлэлийн нэг тохиолдолд тооцно.		Түргэн тусламжийн зардлын бүрэлдэхүүнд эмчийн үзлэг, газар дээр нь үзүүлсэн тусламж, үйлчилгээнд ашиглагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, тээвэр, шатахууны зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.
	Бусад зохицуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан түргэн тусламжийн оношийн хамааралтай бүлгийн "км" нь тухайн түргэн тусламжийн нэг талын зайг илэрхийлнэ 2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймаг, дүүргийн эмнэлэг рүү, аймгаас Улаанбаатар хот руу эсхүл ойролцоо төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжтай эрүүл мэндийн байгууллага руу өвчнийг эмчийн хяналтын дор тээвэрлэн шилжүүлэхтэй холбоотой зардлыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан холбогдох түргэн тусламжийн бүлгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг баримтлан санхүүжүүлнэ. 3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн эмнэлгээс ирүүлсэн дуудлагын дагуу аймгаас өрх, сум тосгоны эмнэлэг рүү, Улаанбаатар хотоос аймаг руу эмч, баг очин, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн тохиолдлын зардлыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан холбогдох түргэн тусламжийн бүлгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг баримтлан санхүүжүүлнэ. 4. Түргэн тусламжийн дуудлагад лавлагаа шатлалын эмнэлэг хоорондын эмчийн дуудлагын үйлчилгээ хамаарахгүй. 	

		5. Түргэн тусламжийн хуурамч дуудлага өгч, үйлчилгээ авсан тохиолдолд тухайн түргэн тусламжийн харгалзах төлбөрийн хэмжээг баримтлан, төлбөрийг иргэнээр төлүүлнэ.	
11. Телемедицинний тусламж, үйлчилгээ			
Телемедицинний тусламж, үйлчилгээ	Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлэг, клиникийн хүсэлтийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас авч буй телемедицинний тусламж, үйлчилгээний тохиолдол бүрийг нэг тохиолдол гэнэ.		Телемедицинний тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд зөвлөгөө өгч буй эмчийн зөвлөгөө, интернетийн зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна.
	Бусад зохицуулалт		Зөвхөн эрчимт эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээний үед эмнэлзүйн тусгай програм хангамжийг ашиглан эмчилгээ, оношилгоо үзүүлсэн тохиолдолд телемедицинний тусламж, үйлчилгээ гэж тооцон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

5.2. ЭМД-ын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээний хувьд энэхүү журмын 5.1-т тодорхойлсон удирдамжаар зохицуулаагүй тохиолдлыг санхүүжүүлэх зэвхийг ЭМД-ын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

5.3. ЭМД-ын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж төлбөрийн хэмжээг санхүүжүүлэхдээ энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад харгалзах "ЭМД-ын сангаас төлөх" төлбөрийн хэмжээг баримтална.

Зургаа. Журам зөрчигсөд хүлээлгэх хариуцлага

6.1. Эрүүл мэндийн байгууллага даатгуулагчид шаардлагагүй эмчилгээ, үйлчилгээ санал болгох, холбогдох оношийг өндөр өртөг бүхий оношийн бүлэг рүү хувирган нэхэмжлэх зэрэг хууран мэхлэх зөрчил гаргасан нь нотлогдсон бол холбогдох хууль, журам, гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

6.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасан "Иргэний хариуцан төлөх төлбөр"-өөс өөр төлбөрийг иргэнээс авсан тохиолдолд иргэнээс авсан нэмэлт төлбөрийн хэмжээтэй дүйцэх санхүүжилтийг дараагийн санхүүжилтээс бууруулах, дахин давтагдавал гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авна.

---oOo---

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01
дүгээр тогтоолын дөрөвдүгээр хэсгээс

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин,
эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт

2.1. Сүрьеэ

- Пиразинамид (шахмал 500мг)
- Этимбутол (шахмал 100 мг, 275 мг, 400 мг)
- Рифамидин (капсул/шахмал 150 мг, 300 мг)
- Изониазид (шахмал 50 мг, 75 мг, 100 мг, 300 мг)
- Стрептомицин (тарилгын нунтаг 1 гр, флаконтой)
- Эдгээр эмийн хослол

2.2. Хорт хавдрын гурав, дөрөвдүгээр үе шат /хөнгөвчлөх эмчилгээ/

- Морфин, даруй сулардаг (шахмал 10 мг)
- Морфин, удаан сулардаг (шахмал 30 мг)
- Морфин (тарилгын уусмал 1% 1 мл тун шилтэй)
- Кодеинфосфат (шахмал 30 мг)
- Кодеинфосфат 30 мг + Парацетамол 500 мг (шахмал)
- Трамадол (капсул 50мг, шахмал 100 мг, дусал)
- Трамадол (50 мг/мл, 75 мг/3 мл, 100 мг/2мл тун шилтэй)

2.3. Сэтгэцийн эмгэг

- Амитриптилин (шахмал 25 мг)
- Галоперидол (шахмал 1.5 мг, 5 мг)
- Диазепам (шахмал 2 мг, 5 мг, 10 мг)
- Литийн карбонат (капсул/шахмал 300 мг, 500 мг)
- Мегадон (шахмал 5 мг, тарилгын уусмал 10 мг/мл)
- Хлорпромазин (шахмал 100 мг)
- Фенобарбитал (шахмал 15 мг, 30 мг, 100 мг)
- Флуфеназин (тарилгын уусмал 25 мг/мл)
- Левомепромазин (шахмал 25 мг)

2.4. Удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэг

2.4.1. Чихрийн шижин

- Инсулин (тарилгын уусмал 100 ОУН/мл-3мл/ленфил, 10мл/фл)
 - Хэт богино хугацааны үйлдэлтэй инсулин
 - Богино хугацааны үйлдэлтэй инсулин
 - Дунд хугацааны үйлдэлтэй инсулин
 - Урт хугацааны үйлдэлтэй инсулин
 - Холлимог инсулин
- Глибенкламид (шахмал 2.5 мг, 5 мг)
- Метформин (шахмал 500 мг, 850 мг)

- Гликлазид (шахмал 30 мг, 80 мг)

2.4.2. Чихрийн бус шижин

- Десмопрессин (минирин /шахмал 0.1 мг, 5 мл хамрын дусаалга)

2.4.3. Бамбай булчирхайн дутмагшил (гипотиреоз)

- Левотироксин (шахмал 25 мг, 50 мг)
- Триодтрионин (шахмал 20 мкг)

2.4.4. Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил

- Соматропин (үзгэн тариур 10 мг/1.5 мл)

2.4.5. Паркинсоны өвчин

- Левадопа + Карбидопа (шахмал 100 мг + 10 мг, 250 + 25 мг)

2.4.6. Уналт таталт /Эпилепси/

- Карбамазепин (шахмал 200 мг)
- Вальпроны хүчил (шахмал 200 мг, 500 мг)

2.4.7. Миастени

- Неостигмин (шахмал 10 мг, тарилгын уусмал 500 мкг/мл)
- Галантамин (тун шил 1% 0.25-1 мл)

2.4.8. Нүдний даралт ихсэх өвчин /Глаукома/

- Пилокарпин (нүдний дусал 2%, 4%)
- Тимолол (нүдний дусал 0.25% , 0.5%)

2.4.9. Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал

- Такролимус (капсул 0.5 мг, 1 мг, 5 мг)
- Циклоспорин (капсул 25 мг)

2.4.10. Дархлалын олдмол хомсдол өвчин

- Ацикловир (шахмал 200 мг, 400 мг, 800 мг)
- Зидовудин /AZT/ (капсул 100 мг, 250 мг)
- Ламивудин /3TC/ (шахмал 150 мг, 300 мг)


2.4.11. Гемофилли

- Гемофилийн эсрэг фактор (хуурай фактор VIII, IX – 250 ОУН – 3000 ОУН)

---oOo---

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01
дүгээр тогтоолын тавдугаар хавсралт



**ТӨЛБӨРИЙГ НЬ ТӨР ХАРИУЦАХ ЭМИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТООЦОХ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эм (цаашид "төлбөрийг нь төр хариуцах эм" гэх) жагсаалтад багтсан эмийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Төлбөрийг нь төр хариуцах эм олгох үйлчилгээг төрийн өмчийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг үзүүлнэ.

Хоёр. Төлбөрийг нь төр хариуцах эмийг иргэнд олгох

2.1. Төлбөрийг нь төр хариуцах эм олгож байгаа эрүүл мэндийн байгууллага нь энэхүү эм авах шаардлагатай иргэний нөхцөл байдлыг Эмнэлэг хяналтын комиссоор тухай бүр хэлэлцэн баталгаажуулж, иргэнийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байлгана.

2.2. Сүрьеэгийн эмээс бусад эмийг амбулаториор олгоходоо энэ журмын 2.1-т заасны дагуу эмчийн хяналтад байгаа өвчтөнд нэг сарын хугацаанд хэрэглэгдэх эмийг сар бүр олгоно. Эмнэлэг, хяналтын комиссын шийдвэрээр зарим өвчтөнд 3 сар хэрэглэх хэмжээний эмийг олгож болох бөгөөд зориулалтын асуудлыг тухайн өвчтөнийг хяналтад авсан эмнэлэг хариуцна.

2.3. Эм олгох үйл ажиллагааг энэ журмын 1.2-т заасан эмнэлгийн байгууллагын эмийн сан эрхэлнэ. Шаардлагатай тохиолдолд төр хариуцах эмийг олгох үйл ажиллагааг сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр гүйцэтгүүлж болох бөгөөд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар зохицуулалтыг хийж, төсөв хуваарилах, эмээр хангах ажлыг зохион байгуулна.

2.4. Өвчтөний хяналтыг хариуцсан эмч эмийн жорын стандарт MNS 5376.2008-аар батлагдсан жорын маягтад эмийг бичиж, эмчилгээ, хяналтын картад нь тэмдэглэнэ.

2.5. Эдгээр эмээр эмчлэх явцад тунг өвчтөн бүрд эмчлэгч эмч тохируулж, хэрэглээнд хяналт тавина.

2.6. Иргэн оршин суугаа газраасаа шилжсэн тохиолдолд эмчилгээ хийж байсан эмнэлгийн байгууллага нь шилжүүлэг хийж өгөх бөгөөд шилжин очсон

газрынх нь харьяаллын эмнэлгийн байгууллага түүний бүртгэн аач эмчилгээг нь чирэгдэлгүй үргэлжлүүлнэ.



**Гурав. Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтийг тооцох,
эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх**

3.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ) төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтад шаардагдах хөрөнгийн хэмжээг эмийн хэрэгцээ шаардлага, зах зээл дэх үнэ, эрүүл мэндийн байгууллагад олгосон өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн эм тус бүрээр тооцно.

3.2. Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтийн хэмжээг ЭМДЕГ-аас эрүүл мэндийн байгууллагатай хийх тусламж үйлчилгээний гэрээний хавсралтад тусгаж батлах бөгөөд гэрээнд заасан санхүүжилтийн хэмжээ хүртэл гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

3.3. Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилтийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад сар бүр олгох бөгөөд энэхүү журмын 3.2-т заасан гэрээний жилийн дүнг сар бүр тэнцүү хуваарилна.

3.4. Төлбөрийг нь төр хариуцах эмийн жагсаалтад орсон эмийн онцлог, нийлүүлэлтийн нөхцөлөөс хамааруулан тухайн эмийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад улирлаар, жилээр урьдчилан олгож болох бөгөөд уг холбогдох зохицуулалтыг эрүүл мэндийн байгууллага, ЭМДЕГ хоорондын гэрээнд тусгайлан заана.


Дөрөв. Бусад

4.1. Эрүүл мэндийн байгууллагууд төлбөрийг нь төр хариуцах эмийн зарцуулалтын тайланг ЭМДЕГ-т сар тутам гаргаж ирүүлнэ.

4.2. Төлбөрийг нь төр хариуцах эмийг энэ журамд зааснаас өөрөөр олгож зарцуулсан нь нотлогдсон бол албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.3. ЭМДЕГ нь төлбөрийг нь төр хариуцах эмийн олголтод улирал бүр хяналт, үнэлгээ хийнэ.

---oOo---


**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
 ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
 ТОГТООЛ**

НБАА 09/01 сарын 28 өдөр
 Дугаар *02*
 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай:
 - Эрүүл мэндийн яамны Төрийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д:
 - Улсын хэмжээний орны зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн нэгдсэн мэдээллийн санг аймаг, нийслэл, сум, дүүргээр ялган харах боломжтой байдлаар бүрдүүлэх, уг мэдээллийн санд бодит цагийн горимоор хандах боломжийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт олгох, нэгдсэн мэдээллийн сан бүрдэх хүртэлх хугацаанд өөрчлөлт орсон мэдээлэл бүрийг хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т:
 - Сонгон шалгаруулалт зарлах тусламж, үйлчилгээний төрөл тус бүрээр тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад тавигдах "Тусгай шаардлага"-ыг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тусламж, үйлчилгээний нэр, төрөл, жагсаалтад суурилан боловсруулан батлах, нэр, төрөл, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүрт шинэчлэх;
 - Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн болон нэмэлт сонгон шалгаруулалтыг батлагдсан журмын дагуу зохион байгуулах;
 - Эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулалтын журам, шалгуур, цахим системийн талаарх мэдээллээр ханган ажиллах;
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны "Журам батлах тухай" 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2022 оны 02 дүгээр сарын 28-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар иргэн, даатгуулагчид Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.13, 9.4-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг (цаашид "тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага" гэх)-г цахим систем ашиглан сонгон шалгаруулах (цаашид "сонгон шалгаруулалт" гэх), үр дүнг мэдээлэх болон холбогдох бусад харилцааг зохицуулна.

1.2 Сонгон шалгаруулалтын зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудаас тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж, хүртээмжийг нь харгалзан сонгож, иргэн даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад оршино.

1.3 Сонгон шалгаруулалт нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

1.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан улсын төсөөр санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг сонгон шалгаруулалтад хамруулахгүйгээр тэдгээр байгууллагатай шууд гэрээ байгуулж болно.


Хоёр. Сонгон шалгаруулалтын зарчим

2.1 Сонгон шалгаруулалтад дараах зарчим баримтална:

2.1.1 **Үр ашигтай байх:** Даатгуулагчдын дийлэнх олонхийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэлзүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагаас худалдан авна.

2.1.2 **Чадамжид суурилсан байх:** Сонгон шалгаруулалт нь тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын чадамж, хүртээмжийн талаарх бодит үнэлгээнд суурилсан байна.

2.1.3 **Хүлээн зөвшөөрсөн байх:** Сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтоосон тусламж үйлчилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргыг хүлээн зөвшөөрсөн байна.



2.1.4 **Ил тод, нээлттэй байх:** Сонгон шалгаруулалт нь ил тод, нээлттэй явагдах бөгөөд үр дүнг олон нийтэд мэдээлдэг байна.

2.1.5 **Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:** Сонгон шалгаруулалт нь цахим технологид суурилсан, хувь хүний хүчин зүйлээс ангид, хараат бус хэлбэрээр явагдана.

Гурав. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

3.1 Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах, зохион байгуулах, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийн санал боловсруулах үндсэн нэгж нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж байна.

3.2 Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангахад Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтныг татан оролцуулж болно.

3.3 Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажилд дараах үйл ажиллагаа хамаарна:

3.3.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, жагсаалт бүрт тавигдах "Тусгай шаардлага"-ыг боловсруулан батлуулах, нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүрт "Тусгай шаардлага"-ыг шинэчлэх;

3.3.2 Ерөнхий болон тусгай шаардлагыг үнэлэхэд шаардлагатай дараах мэдээллийн бааз үүсгэх, шинэчлэх;

3.3.2.1 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан;

3.3.2.2 эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн мэдээллийн сан;

3.3.2.3 эмч, эмнэлгийн мэргэжилтний эмчлэх, сувилгах, эм барих зөвшөөрлийн мэдээллийн сан;

3.3.2.4 эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий байгууллагуудын сүүлийн 3 жилийн гэрээний үнэлгээний мэдээллийн сан;

3.3.2.5 хугацаанаас өмнө гэрээ цуцалсан, түүний шалтгаан, хууран мэхлэх аливаа асуудал зэргийг агуулсан зөрчлийн мэдээллийн сан;

3.3.3 Сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахад ашиглах системийн бэлэн байдлыг хангах;

3.3.4 Сонгон шалгаруулалтын үе шат болон сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага зэрэг мэдээллийг цогц байдлаар бэлтгэх түгээх;

3.4 Сонгон шалгаруулалтын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан нь энэхүү журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалттай холбогдох үндсэн чиг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.4.1 Сонгон шалгаруулалтыг аливаа ашиг сонирхлын зорчлоос өнгөц, сонгон шалгаруулалтад оролцогч эрүүл мэндийн байгууллага, түүний удирдлага, эрүүл мэндийн даатгалын харилцагчид оролцогч бусад талуудаас хараат бус, бие даасан байдлаар энэхүү журмын 1.3-т заасан холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах;

3.4.2 Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад болон бусад этгээдэд задруулахгүй байх;

3.4.3 Сонгон шалгаруулалтын явц, үр дүнд үүссэн санал, хүсэлт, гомдол, маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх;

Дөрөв. Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа, нөхцөл

4.1 Сонгон шалгаруулалтыг гурван жилд нэг удаа нэгдсэн журмаар (цаашид "нэгдсэн сонгон шалгаруулалт" гэх) зохион байгуулна.

4.2 Нэгдсэн сонгон шалгаруулалтыг эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нийт нэр төрлөөр эсхүл тусламж, үйлчилгээний тухайн төрөл тус бүрээр нь зарлаж болно.

4.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний нэр төрөлд нэмэлт, өөрчлөлт орсон эсхүл тусламж, үйлчилгээний хүртээмж нь хангалтгүй тусламж, үйлчилгээний хувьд нэгдсэн сонгон шалгаруулалтын үр дүн, үйлчлэх хугацааг үл харгалзан нэмэгдсэн нэр төрөл бүрээр нэмэлт сонгон шалгаруулалт зохион байгуулж болно.


Тав. Сонгон шалгаруулалтад оролцогч эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

5.1 Сонгон шалгаруулалтад оролцогч эрүүл мэндийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд сонгон шалгаруулалтад орох бөгөөд "Ерөнхий шаардлага" болон "Тусгай шаардлага" гэсэн үндсэн 2 төрлийн шаардлагыг хангасан байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрлийн сонгон шалгаруулалтад зөвхөн Эрүүл мэндийн сайдын тушаал болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар баталсан ор бүхий эрүүл мэндийн байгууллага оролцоно.

5.2 "Ерөнхий шаардлага" нь сонгон шалгаруулалтад оролцогч нийт байгууллагад нийтлэг тавигдах доорх шаардлагууд байна. Үүнд:

5.2.1 Хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх;

5.2.2 Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;



5.2.3 Магадлан итгэмжлэгдсэн байх;

5.2.4 Нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн, сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шимтгэлийн өргүй байх;

5.2.5 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авч үнэлгээ хийгдэж эхлэх өдрийн байдлаар татварын өргүй байх;

5.2.6 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шүүхийн шийдвэрээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээгүй байх;

5.2.7 Нэмэгдсэн өргийн албан татварын удирдлагын систем /НӨАТ/С-и-баримт/д холбогдсон. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын цахим мэдээллийн санд хандах техникийн боломжтой, мэдээлэл дамжуулах загварын дагуу тогтоосон шаардлагад нийцүүлж системийг хөгжүүлэх, хөвийн ажиллагааг хангах чадамжтай байх;

5.3 "Тусгай шаардлага" нь сонгон шалгаруулалтад оролцогч эрүүл мэндийн байгууллага тухайн тусламж, үйлчилгээг нотолгоонд суурилсан эмнэлзүйн хувьд үзүүлэх чадамжтай эсэхийг үнэлэхэд баримтлах нөөцийн шаардлага бөгөөд тусламж, үйлчилгээний нэр төрөл тус бүрээр ялгаатай байна.

5.4 "Тусгай шаардлага" нь "Зайлшгүй шаардлага" болон "Нэмэлт шаардлага" гэсэн дараах 2 үндсэн хэсгээс бүрдэнэ:

5.4.1 "Зайлшгүй шаардлага" гэдэг нь тухайн эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэхэд нэн шаардлагатай хүний нөөц, лаборатори, тоног төхөөрөмж, байгалийн нөөц, барилга байгууламжийн нөөц бөгөөд тус нөөцийг өөрийн хүчин чадлаар бүрдүүлж, тусламж, үйлчилгээний тоо хэмжээнээс үл хамааран байнгын бэлэн байдалд байлгана.

5.4.2 "Нэмэлт шаардлага" гэдэг нь эрүүл мэндийн байгууллага шаардлагатай тохиолдолд нэмэлтээр ашиглаж болох нөөц бөгөөд уг шаардлагыг өөрийн нөөцөөр эсхүл тус шаардлагыг хангаж чадахуйц, мэргэжлийн байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлэх замаар биелүүлэх боломжтой байна.

5.5 Тусгай шаардлагад орон нутгийн хязгаарлагдмал нөөц, боломжийг харгалзан үзэж болно.

Зургаа. Сонгон шалгаруулалт зарлах

6.1 Сонгон шалгаруулалтын урилгыг "Сонгон шалгаруулалтын нэгдгээр үе шат"-ны материалыг хүлээн авч эхлэх өдрөөс ажлын 7-оос доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсанд байршуулна.

6.2 Сонгон шалгаруулалтын урилгын загварыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батална.

Долоо. Сонгон шалгаруулалтын үе шат

7.1 Сонгон шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулна:



7.2 Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатыг дараах байдлаар зохион байгуулна:

7.2.1 Тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын хүсэлтийг сонгон шалгаруулалт зарласнаас хойш ажлын 10 хоногийн хугацаанд цахим системээр хүлээн авна.

7.2.2 Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатын үнэлгээг сонгон шалгаруулалтын хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор багтаан цахимаар зохион байгуулна.

7.2.3 Сонгон шалгаруулалтын цахим систем нь эрүүл мэндийн байгууллагын регистрийн дугаар эсхүл "Ерөнхий шаардлага"-ын дагуу ирүүлсэн материалыг холбогдох төрийн захиргааны байгууллагаас урьдчилан цуглуулсан мэдээлэлтэй харьцуулах замаар үнэлгээг хийнэ.

7.2.4 "Ерөнхий шаардлага"-ыг бүрэн хангасан байгууллагыг сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд тэнцсэнд тооцно. "Ерөнхий шаардлага"-аас аль нэг шаардлагыг хангаагүй тохиолдолд нэгдүгээр үе шатанд тэнцээгүйд тооцно.

7.2.5 Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд тэнцсэн байгууллагад сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатын мэдээллийг цахимаар ирүүлэх, тэнцээгүй байгууллагад сонгон шалгаруулалтад тэнцээгүй тухай мэдэгдлийг үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн байгууллагын цахим хаягаар хүргүүлнэ.

7.2.6 Нэгдүгээр үе шатанд тэнцсэн байгууллагад хүргүүлэх, сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатын мэдээллийг цахимаар ирүүлэх мэдэгдэл нь дараах мэдээллийг агуулсан байна.

7.2.6.1 Тухайн сонгон шалгаруулалтаар худалдан авах тусламж, үйлчилгээний нэр төрөл, дэлгэрэнгүй жагсаалт;

7.2.6.2 Тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад тавигдах "Тусгай шаардлага";

7.2.6.3 "Тусгай шаардлага"-ыг хангаж буйг нотлох баримт бичгийн мэдээлэл;

7.2.6.4 "Тусгай шаардлага"-ын материалыг сонгон шалгаруулалтын цахим системд хэрхэн илгээх зааварчилгаа;

7.2.6.5 Хоёрдугаар үе шатын мэдээллийг хүлээн авах эцсийн хугацаа;

7.2.6.6 Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, зааварчилгаа өгөх албан тушаалтны нэр, холбоо барих утасны дугаар;

7.3 Сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатыг дараах байдлаар зохион байгуулна:

7.3.1 Нэгдүгээр үе шатанд тэнцсэн эрүүл мэндийн байгууллага нь "Тусгай шаардлага"-д заасан мэдээллийг мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор цахим системд оруулж баталгаажуулна.

7.3.2 Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн чадамж, үндсэн үзэгдэс дээш төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх сонголтыг өгөгдсөн жагсаалтын дагуу хийж болох бөгөөд сонгосон тусламж, үйлчилгээний төрөл нь тухайн байгууллагын тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны төрөлтэй нийцсэн байна.

7.3.3 Сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатын үнэлгээ буюу мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээг мэдээлэл хүлээн авч дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор зохион байгуулна.

7.3.4 "Зайлшгүй шаардлага" болон "Нэмэлт шаардлага"-д тавигдсан шалгуурыг бүрэн хангасан байгууллагыг сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцсэнд тооцож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тэнцсэн тухай мэдэгдлийг үнэлгээ дуусч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталгаажсанаас хойш ажлын 3 хоногт багтаан тухайн байгууллагын цахим хаягаар хүргүүлнэ.

7.4 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж нь сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тэнцсэн эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл, газар зүйн байршлаар ангилан гаргаж, тухайн бүс нутагт үзүүлэх тусламж, үйлчилгээний эрэлтийг хангаж байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

7.5 Энэ журмын 7.4-т заасан үнэлгээгээр бүс нутгийн хэмжээнд үзүүлэх тусламж, үйлчилгээний эрэлтийг хангахааргүй бол дахин сонгон шалгаруулалт зохион байгуулж болно.

Найм. Сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулах, мэдээлэх

8.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатын үнэлгээ хийгдэж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор тушаал гаргаж, сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулна.

8.2 Энэ журмын 8.1-т заасан тушаалд сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын жагсаалтад газар зүйн байршил, үзүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг тусгасан байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудтай тушаал гарснаас хойш хуанлийн 15 хоногт багтаан гэрээ байгуулна.

8.3 Сонгон шалгаруулалтын эцсийн үр дүнг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсанд байршуулна.

8.4 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь сонгон шалгаруулалтын үр дүнгийн тайланг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд энэ журмын 8.1-т заасан сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулсан тушаал гарснаас хойш нэг сарын дотор хүргүүлнэ.

Ес. Сонгон шалгаруулалттай холбогдох маргааныг шийдвэрлэх

9.1 Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын үйл явц, үр дүнгийн талаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас тодруулга авах, хуульд

өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд өөрчлийн нотлох баримтыг хавсаргана.

9.2 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь сонгон шалгаруулалтад оролцогчоос гаргасан сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг хүлээн авснаас хойш түүнийг гомдол барагдуулах ажиллагаанд оролцохыг урин. Гомдол гаргагч нь уг ажиллагаанд оролцоогүй тохиолдолд цаашид гомдол гаргах эрхгүй.

Арав. Хариуцлага

10.1 Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас сонгон шалгаруулалтын явц, үр дүнд нөлөөлсөн нь нотлогдсон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.2 Эрүүл мэндийн байгууллага нь хуурамч баримт бичиг бүрдүүлж сонгон шалгаруулалтад оролцсон нь тогтоогдсон бол тухайн эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээг цуцалж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх бөгөөд дараагийн 3 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

---000---



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



EMDaatgal



@Eruul_mendiin_daatal



Эрүүл мэндийн даатгал